



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 01/193

Жавхлант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1.дэх заалт 9.1.3 дахь заалт 10 дугаар зүйлийн 10.4.4. дэх заалт дугаар зүйлийн 10.3.5, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 242 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Дэлгэрхаан багийн их дэв гэх газар малын гоц халдварт шүлхий өвчин болох нь Мал эмнэлгийн ерөнхий газраас батлагдаж ирсэн тул шүлхий өвчинтэй тэмцэх хариу арга хэмжээний зардалд 1,887,500 (нэг сая найман зуун наян долоо мянга таван зуун) төгрөгийг зарцуулсугай.

2.Төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Уранбайгаль)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Шаравгаваа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Г.ЭНХЗАЯА